

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Лидер хүн байх эрх

Удирдах байр суурьны хүнд байх ёстой чадварууд гэвэл урьдчилан харах, шийд гаргах гээд олон зүйлийг нэрлэж болно. Гэвч тэр дотроос энэ л байхгүй бол удирдагч байх эрх байхгүй гэж хэлж болох хамгийн чухал зүйл юу вэ? Тэр бол хүмүүсийн итгэлийг хүлээх чадвар гэж би бодож байна.

Хүмүүсийн итгэлийг олж авч чадахгүйгээр хичнээн гайхалтай үг хэллээ гээд хүмүүсийн сэтгэлд хүрч чадахгүй. Харин хүмүүсийн итгэлийг хүлээсэн лидер ганцхан үгээр бусдын сэтгэлийг өөрчилж чадах тохиолдол ч байдаг.

Тэгвэл яавал хүмүүсийн итгэлийг хүлээх вэ? Хамгийн түрүүнд шударга байх чухал. Хүмүүсийн нүдэнд ил байх үедээ ч далд байх

үедээ ч нэг янзаараа байх. Түүнчлэн бусдыг бодох, хүндэтгэх сэтгэлтэй байх явдал юм.

Дээд албан тушаалтантай харьцахдаа эелдэг зөөлөн байх хэрнээ доод албан тушаалтантайгаа харьцахдаа тэс өөр хүн болж, чангаар загнаж, зандардаг хүн бол бусдын итгэл хүлээхэд бэрх. Тийм хүн бол өөрийн байр суурийг л боддог хүн юм.

Харин лидер бол өөрийгөө хойш тавьж, бусдын аз жаргалыг боддог хүн байдаг. Аз жаргалтай байх, амжилттай байх нь хүмүүс хоорондын харилцаанаас шалгаална. Хүмүүс хоорондын харилцааг чухалчилж чаддаггүй хүн бол өөр юу ч хийсэн үр дүнд хүрч чадахгүй гэж хэлэхэд буруудахгүй.

Living the Lotus Vol. 154 (July 2018)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Б. Мөнхцэцэг

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Сэтгэл засаж, тайтгарал авчрах үг

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Шударга, хичээнгүй амьдрах

Шагжамүни бурхан багшийн үндсэн сургаал болох “Хутагтын найман зөв зам”-ын нэг нь “зөв үг” юм. Энэ нь Үнэн дармад нийцсэн үг хэлэхийг хэлэх боловч “зөв ярих” гэдгийг бид энгийн үед тэр болгон ухамсарлаад байдаггүй мэт санагдана. Тиймээс “зөв үг” гэж юу вэ гэдгийг заалгасан ч шууд амьдралдаа хэрэгжүүлдэг хүн тийм ч олон байхгүй болов уу. Гэхдээ бид өдөр тутамдаа хүмүүстэй харилцахдаа уур амьсгалыг зөөллөж, сэтгэл засах үгийг өөрийн эрхгүй хэлж байдаг. Яагаад гэвэл тэр нь илүү сэтгэлд таатай, мөн тайвшруулдаг болохоор юм.

“Зөв үг” гэдгийг “үр өгөөжтэй үг хэлэх” гэж ойлгож болох бөгөөд эв найрамдал, нэгдэл нь бидний амьдралд маш чухал ухагдахуун, өөрөөр хэлбэл үр өгөөжтэй зүйл учраас тухайн орчны уур амьсгалыг зөөллөх, сэтгэл засах үг гэдэг нь маргаангүй “зөв үг” юм. Тэр утгаараа бид өөрийн мэдэлгүй “зөв үг”-ийг хэлж байдаг гэж хэлж болно.

Гэвч бид заримдаа орчны уур амьсгал, эв найрамдлыг бусниулах үгийг хэлж орхидог. Үүнд хамгийн түрүүнд өөртөө нийцүүлж худлаа ярих, үнэн зөвийг гуйвуулж бусдад дамжуулахыг хэлнэ. Шагжамүни бурхан багш убашаи (лам бус гэргийтэн) шавь нартаа зориулсан сургаалдаа “бусдад худал хэлж үл болно” хэмээн тодорхой хэлсэн байдаг. Мөн “өөрийгөө зовоохгүй, бусдыг эмзэглүүлэхгүй үгээр ярих хэрэгтэй” гэж хэлсэн байдаг. Худал үг бусдыг төөрөлдүүлж, эв найрамдлыг алдагдуулахаас гадна эцсийн эцэст өөрийг зовоодог. Ингээд бодоод үзэхээр “зөв үг”-ийг хэрэгжүүлэхэд юу чухал вэ гэвэл, юуг яаж ярих вэ гэдгээс илүү шударга, зөвөөр амьдрах чухал гэж ойлгож болох болов уу.

Үгний утгаар зогсохгүй, хүнтэй харилцах, биеэ явч явах байдлын талаар дурьдахад Нобелийн энхтайвны шагналын сонгон шалгаруулах хорооны гишүүнээр ажиллаж байсан Норвегийн нийгэмлэгийн Осло хотын хүндэт хамба Гүннар Сталсэт (30 дахь удаагийн Ниваногийн нэрэмжит энхтайвны шагналын эзэн) өөрийн эрхгүй санаанд ордог.

Сталсэт хамба нь олон улсын хурал дээр хүмүүсийн санал хуваагдах үед маш чавдарлагаар асуудлыг шийддэг нэгэн юм. Ингэж хэлэхээр хамбатанг маш сайхан ярьдаг хүн гэж ойлгож магадгүй. Гэтэл тийм биш,

харин ч тэрээр дуугай талдаа хүн. Янз бүрийн санал, хэлэлцүүлэгийг анхааралтай сонсоод, тайвнаар өөрийн саналыг хэлэхийн далимд төгсгөлд нь “ингэж шийдвэл ямар вэ?” гэж хүмүүсийн саналыг асууна.

Өөр байр суурьтай хүмүүс цугласан газар санал хуваагдах үе байна. Ийм үед бусдын саналыг сайн сонсож, санаа бодлыг нь хүлээн авах сэтгэл болоод хувиа хичээсэн үзлээ дарж бусдыг хүндэтгэсэн эрх тэгш байр суурьнаас хэлсэн үг эв найрамдлыг авчрах болов уу. Хамбатаны энэхүү биеэ авч явах байдалд “зөв үг”-ний утгын хамгийн гол цөм агуулагдаж байна гэж бодож байна.

Хайр нигүүлсэл

Япон хэлээр “愛хайр” гэдэг ханзыг “канаши” гэж дууддаг. Хайрлах гэдэг нь өрөвдөн энэрэх гэсэн утгыг ч агуулдаг гэсэн үг юм. Эх хүн хүүхдээ хайрлан энхрийлэх сэтгэл гэж хэлбэл ойлгомжтой байх. “Зөв үг” өөрөөр хэлбэл “зөвөөр ярих” гэдэг ойлголт дотор хайрлах сэтгэл, өрөвдөн энэрэх сэтгэл болон бусдад аз жаргалыг хүсэх сэтгэл агуулагддаг гэсэн үг.

“Элбэрэлт зөөлөн үг хайрын сэтгэлээс төрмүй, хайрын сэтгэл нигүүлсэнгүй сэтгэлээс улбаатай” гэдэг Зэн урсгалын Доогэн багшийн хэлсэн үг байдаг. Сталсэт хамбатаны үгэнд шашин болгонд байдаг нийтлэг ойлголт болох нигүүлсэнгүй сэтгэл агуулагдаж байдаг болохоор л ямар ч хүн хүлээж авдаг болов уу.

Мөн Рёокан ламтаны зугаа цэнгэлд толгойгоо мэдүүлсэн үеэл дүүгээ ухааруулан аварсан ганц зүйл бол учирлаж тайлбарласан үг ч биш, загнаж зандарсан үг ч биш харин үеэл дүүгийнхээ төлөө урсгасан ганц дусал нулимс байсан. Заавал үг хэлэхгүйгээр, хайр нигүүлсэлээр бялхсан нам гүм байдлаар нөгөө хүнд дамжих “зөв үг” гэж бас байдаг гэсэн үг.

Удахгүй дэлбээлэх цэвэр ариуны бэлгэдэл бадамлянхуа цэцгийг таашаангаа өвөг дээдэстээ буян хураах Үрабоны энэ үеэр бидэнд аз жаргалыг хэнээс ч илүү хүсдэг эцэг эх болон өвөг дээдсийн хайр нигүүлслийг дахин нэг тунгаан үзэхэд илүүдэхгүй болов уу.

“Косей” сэтгүүл 7-р сарын дугаараас





Гакүрин сургуульд сурсан зүйл



Сахан Чамара Динггантиригэ
Шриланк нийгэмлэг

*Энэ илтгэл 2018 оны 3-р сарын 1 өдөр Их Ариун ордонд зохион
байгуулагдсан амин өдрийн ёслол дээр тавигдсан болно.*

Миний бие 1994 онд Шриланкийн нийслэл Коломбогийн ойролцоох Үэрүмирура гэдэг тосгонд айлын том хүү болон мэндэлсэн. Эцэг эх, 2 дүүгийн хамт амьдардаг.

Би ахлах сургуульд орох хүртлээ 2 удаа сургуулиа сольсон. 2 дахь удаагаа шилжиж очсон сургуулийн дээд ангийн хүүхдүүд намайг дээрэлхэж, мөнгийг маань булаах тохиолдол цөөнгүй байснаас сургуульдаа явах надад хүнд санагддаг байлаа. Намайг байнга шоглодог дээд ангийн хүүхдүүдэд уур хүрч, тэднээс илүү хүчтэй болоод хариуг нь хүртээ гэж бодоод сургуулийнхаа цэргийн бэлтгэлийн бүлэгт элсэн орж биеэ хөгжүүлж эхлэв. Тэрнээс хойш ахлах ангиа төгсөх хүртлээ миний дургүйг хүргэсэн

дээд ангийн хүүхдүүдтэй үзэлцэж, зодоон цохион байнга хийсээр таарсан. Ахлах ангиа төгссөний дараа ажил хийсэн боловч цалин багатай байснаас 3 жилийн хугацаанд 6-н ч ажил солив. Ямар ч ажил хийсэн олигтой амжилтанд хүрэлгүй, ирээдүйдээ санаа зовж байх үед үеэл дүү маань Косей кайг танилцуулж, элсэн орсон юм.

Залуучуудын бүлгийн үйл ажиллагаа хөгжилтэй санагдсанаас гадна хоозад хүртэл ордог болов. Эхэндээ бусдын яриаг дуугүй сонсдог байсан боловч өөрсдийнхөө талаар нуулгүй ярих найз нарыгаа хараад өөрийнхөө тухай ч ярьдаг болов. Үнэндээ би ахлах ангидаа байх үеийнхээ зодоон хийдэг ширүүн дориун байх үеэ эцэг эхдээ төвөг удахгүй гэсэндээ нуудаг байсан ба энэ тухайгаа ч хоозад ярьдаг болов. Нийгэмлэгт өөрийнхөө хэргийг хойш тавьж, бусдад туслахыг боддог залуучууд олон байв. Тэдгээр залуусын ачаар би ч гэсэн өөрийн мэдэлгүй бусдын сайн сайхны төлөө гэж боддог, санаа тавьдаг болж төлөвшиж ирснээ анзаарсан. Нийгэмлэгт очих бүрт тэргүүн болон Рүкланти ажилтанаас үүрэг даалгавар авч, сүмийн цэвэрлэгээ, бурханд идээ өргөх, судар уншлагын хонх, дамарыг дарах, залуучуудын бүлгийн үйл ажиллагааны мөнгө санхүүг хариуцах, залуучуудын бүлгийн жилийн төлөвлөгөөг боловсруулах зэрэг төрөл бүрийн үүргийг гүйцэтгэж байв. Надад итгээд үүрэг даалгавар өгч байгаад нь баярлаад, итгэлийг нь алдахгүй юмсан гэсэн сэтгэлээр даалгасан үүрэг даалгаварыг хичээнгүйлэн гүйцэтгэдэг байсан.

Гишүүнээр элсэж ороод 2 жил болоод залуучуудын бүлгийн ахлагчийн үүргийг хүлээн авав. Үүргээ гүйцэтгэж чадах эсэхдээ эргэлзэж байхад залуучуудын бүлгийн залуус маань “бид хамт байгаа болохоор санаа зоволтгүй ээ” хэмээн



Их ариун ордонд илтгэл тавьж байгаа Сахан

дэмжсэн юм. Тэд маань л намайг дэмжиж, тусалсны ачаар РКК-н Гакүрин сургуульд элсэх хүртлээ залуучуудын бүлгийн ахлагчийн үүргийг гүйцэтгэж чадсан.

Гакүрин сургуульд олон зүйлийг сурсан. Тэр дотроос Шизүока мужийн Фүжи нийгэмлэгт дадлага хийх үеийн явдал сэтгэлд тод үлджээ.

Нэг өдөр нийгэмлэгийн 2 гишүүнтэй хамт А гэдэг гишүүний гэрт очихоор болов. Хамт явсан гишүүний яриагаар А гуай өмнө нь шүнин (хэсгийн ахлагч)-ийн үүрэг гүйцэтгэж байсан боловч одоо нийгэмлэгт ирэхээ байсан байв. Тиймээс биднийг гэртээ оруулж ном уншихыг зөвшөөрөх эсэх тодорхойгүй байлаа.

Үүдэн дээрээ гарч ирсэн А гуайд цуг явсан гишүүн “энэ хүн Шриланкаас дадлага хийхээр манай нийгэмлэгт ирсэн” гэж намайг танилцууллаа. Гэтэл гишүүн А биднийг гэртээ орохыг урив. Өмнө нь гишүүд гэрт нь очиход үргэлж үүдэндээ гарч ирж яриад, буцаадаг байсан А гуай гадаадын гишүүн суралцахаар ирсэн гэдэгт баярлаж, биднийг гэртээ орохыг зөвшөөрсөн юм.

Гэрт нь орсны дараа нэгэнт ороод ирсэн юм чинь ном хурж болох уу хэмээн асуухад гишүүн А дуртайяа зөвшөөрөв. Хамт явсан гишүүн намайг голлож уншина уу гэв. Ингээд надад анх удаа Япон айлд япон хэлээр ном голлож унших завшаан тохиолдов. Гишүүн А биднийг сайхан угтан авч, бурхандаа мөргөхийг зөвшөөрсөнд баярлаж, талархсан сэтгэлээр номоо уншив. Би хөлөө нугалан сууж чаддаггүй байсан боловч гайхалтай нь тэр үед судар уншлагыг дуусах хүртэл хөлөө бадайрахыг ч анзаараагүй.

Судар уншлага дуусмагц гишүүн А бидэнд цай хийж өгөөд, нийгэмлэгт очихоо байсан шалтгаанаа яриу. Яриаг нь сонсож байхад гишүүн А РКК-д үнэхээр дуртай гэдэг нь

мэдрэгдэж байв. Хэдийгээр нийгэмлэгт очихгүй байсан ч гишүүн А бурхандаа идээ өргөх, судраа уншихаа таслалгүй, РКК-н гишүүний үүргээ чандлан биелүүлж байсанд сэтгэл хөдлөв.

Нийгэмлэг рүү буцах үед хамт тэдори хийхээр явсан гишүүн: “А гуайн яагаад нийгэмлэгт ирэхээ байсан шалтгааныг мэдэж байсан боловч анх удаа юу бодож байсныг нь өөрөөс нь дууллаа” хэмээн баярлаж байв. А гуай яагаад биднийг гэртээ оруулж, ном уншихыг зөвшөөрсөн нь надад ойлгомжгүй байлаа.

Нийгэмлэг дээр буцаж ирээд тэргүүнд тэдоригаар юу сурснаа илтгэх үед тэргүүн: “Сахан чи судараа ямар сэтгэлээр уншсан бэ?” хэмээн надаас асуув. Би “судар уншихыг зөвшөөрсөнд нь баярлаж, өөр юу ч бодолгүй уншсан” гэж хариулав. Тэгэхэд тэргүүн: “саяхан чи надаас <чин сэтгэл> гэж юуг хэлдэг юм бэ гэж асууж байсан. Өнөөдөр гишүүн А гэрт судар унших үеийн тэр сэтгэл чинь <чин сэтгэл> юм шүү дээ” гэж хэлэв.

Энэ явдлаар дамжуулж толгойдоо олон юм бодож, өөртөө хана босголгүй, цайлган даруу сэтгэлээр тэдорид явах нь чухал гэдгийг сурсан юм.

Шриланкад байх үед хэд хэдэн удаа утасдаж үйл ажиллагаанд оролцохыг урьсан ч ирдэггүй залуу гишүүн байвал “залхуу хүн” гэх мэтээр цоллоод, дахин дуудахаа больчихдог байснаа санаж, өөртөө дүгнэлт хийв. Гишүүдийг үйл ажиллагаанд урихад ирэхгүй байвал дуудахаа болих биш, харин өөрөө тэр гишүүний гэрт нь очиж, чин сэтгэлээсээ гишүүнтэй холбогдож ярилцдаг хүн болох ёстойгоо ойлгосон юм.

3-н сард би Гакүрин сургуулийг төгсөж,


Шриланк руугаа буцна. Одоо Шриланкад гэр бүлийн сургалтыг зохион байгуулах замаар РКК-н сургаал дэлгэрч байна. Сургалтанд хүүхдээ дагуулан ирдэг ээж нар олон байдаг. Шриланкад буцаж очихоороо хүүхдүүдэд сургаалыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж, хөгжилтэй тайван амьдрах арга замыг заах үйл ажиллагааг зохион байгуулъя гэж бодож байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд залуучуудын сэтгэлийг татах ямар үйл ажиллагаа байж болохыг бодож, тэрхүү үйл ажиллагаагаар дамжуулж гишүүдийн сэтгэлийг аварч, дулаан сэтгэлтэй залуу лидерүүдийг бэлтгэхийн төлөө хичээх болно.

Шриланк нийгэмлэгийн тэргүүн Ямамото шинэ жилийн үеэр Японд харьж ирээд байхад нь уулзаж, өөрийнхөө сурсан зүйл, мэдэрч байгаа зүйлээ бүгдийг ярив. Тэгэхэд Ямамото тэргүүн “сургаалыг түгээхээр хамтдаа зүтгэцгээе” гэж хэлсэн. Шриланкад сургаалыг түгээх залуу боловсон хүчин гэж надад итгэж найдаж байгааг нь мэдэрсэн. Нутаг руугаа буцахаараа тэргүүний гар хөл нь болж, нандин сургаалыг түгээхээ тангараглаж, илтгэлээ өндөрлүүлэе.

Анхаарал тавин сонссон та бүхэнд чин сэтгэлээсээ талархал илэрхийлэе.



Гакүрин сургуулийн ангийнхантайгаа
(баруун талаас 2 дахь нь)



Living the LOTUS





Энэ сараас эхлэн Нивано Никкёо багшийн бичсэн “Лянхуан Гурамсан Сударын тайлбар”-ыг цувралаар хүргэх болно. Рисхо косей кай нийгэмлэгийн гол судар болох “Лянхуан Гурамсан Судар”-аас суралцагсаа.

Шагжамүни будда Магада улсын хааны цайзны гадна орших Тас цогцолсон уулнаа “Цагаан лянхуа судар”-ыг айлдахынхаа өмнө “Хязгааргүй утгын тухай судар”-ыг айлдсан. Дараа нь удаан хугацааны туршид бясалгалд орсны дараа “Цагаан лянхуа судар”-ыг айлдаж эхэлсэн.

Энэ дарааллаас аваад үзэхэд Лянхуан Гурамсан Сударын гол багана болох “Цагаан лянхуа судар”-ыг сурахын өмнө эхлээд энэ “Хязгааргүй утгын тухай судар”-ыг унших нь чухал гэдгийг ойлгох байх. Сургаалын агуулгыг онолын үүднээс харсан ч гэсэн “Хязгааргүй утгын тухай судар”-аас эхэлж уншиж байж л “Цагаан лянхуа судар”-ыг жинхэнэ утгаар нь сайн ойлгоно.

Хязгааргүй утга гэдэг нь

Энэ судрын нэрний «хязгааргүй утга» гэдэг нь ямар утгатай вэ гэвэл “хязгааргүй олон утгыг агуулсан сургаал” гэж шууд орчуулж болно. Түүнчлэн энэ “Хязгааргүй утгын тухай судар”-т тэр “хязгааргүй олон утгыг агуулсан сургаал нь цорын ганц жинхэнэ үнэнээс үүдэлтэй” гэдэг талаар айлдсан байдаг. Харин тэр цорын ганц жинхэнэ үнэн гэдэг нь “дүр төрхгүй” гэсэн боловч түүний талаар нарийн дурьдаагүй байдаг. Тиймээс сайн ойлгогдохгүй байгаа юм. Тэгвэл энэ талаар хаана тайлбарладаг вэ гэхээр мэдээж хэрэг дараа нь айлдсан “Цагаан лянхуа судар”-т юм. “Цагаан лянхуа судар”-т тэр талаар бүрэн гүйцэд айлддаг. Түүнчлэн тэр хязгааргүй олон сургаалын үндсийг нэхэн үзвэл “Цагаан лянхуа судар”-т айлдагдах жинхэнэ үнэнээс үүдэлтэй хэмээн амьдралынхаа туршид айлдсан номууд дотроос хамгийн чухал сургаалаа “Хязгааргүй утгын тухай сударт” айлддаг.

Өөрөөр хэлбэл “Хязгааргүй утгын тухай судар”-ын гол хэсэг болох “Ном номлохуйг үгүүлэх 2-р бүлэг”-т Шагжамүни будда Их Чимэглэлт бодисадвагийн асуултанд хариулдаг ба бурханы үйлийг удаан хугацааны туршид хийсэн бодисадва нар биш л бол энэ сургаалыг бүрэн ойлгож чадахгүй гэсэн утгатай. Тийм ч учраас Шагжамүни будда айлдах сургаалынхаа дарааллыг дотроо сайтар бодсон байсан.

Өөрөөр хэлбэл “Хязгааргүй утгын тухай судар”-ыг айлдсаны дараа түүний эх үндэс болох “дүр төрхгүй” буюу “жинхэнэ дүр төрх” гэдэг зүйлийн талаар ямар ч хүнд ойлгомжтойгоор, олон өнцгөөс айлдсан сургаал нь “Цагаан лянхуа судар” юм. Ийнхүү «туйлын үнэн»-ийг анх удаа энгийн хүмүүсийн төлөө айлдсан байна. Тиймээс “Хязгааргүй утгын тухай судар” нь түүнээс ч өмнө байсан уран аргын судруудаас “Цагаан лянхуа судар” гэсэн жинхэнэ үнэний судрыг эхлүүлэх судар бөгөөд “Цагаан лянхуа судар” нь энэхүү “Хязгааргүй утгын тухай судар”-аас эхэлж байж л жинхэнэ утгаараа бүрэн ойлгогддог. Энэ холбооноос үүдээд “Хязгааргүй утгын тухай судар”-ыг “Цагаан лянхуа судар”-ын “оршил судар” гэдэг.





Буяны үйл 1-р бүлэг

Энэ бүлэгт Их Чимэглэлт хэмээх бодисадва Бурхан багшийн төгс төгөлдөр “буян” ба хамаг амьтныг гэтэлгэсэн “үйл”-ийг магтан дуулна.

Шагжамүни буддагийн буяныг магтах

Их Чимэглэлт бодисадва Шагжамүни буддагийн царай төрх, бие бялдар буюу “Бурханы 32 дүр”-ийн гайхамшигийг магтана. Өөрөөр хэлбэл төрсөн бие төрхөд нь цогцолсон төгс төгөлдөр чанарыг магтсан байна. Үргэлжлүүлээд ийнхүү өгүүлнэ.

“Бурхан багш ийм гайхамшигт дүр төрхийг цогцлоосон боловч үнэндээ гайхамшигт чанар нь дүр төрхийг ч давсан бөгөөд эгэл хүний нүдээр түүний мөн чанарыг олж харахад тун хэцүү юм.

Хамаг амьтны мөн чанар ч гэсэн Бурхан багштай адилхан боловч бодит дүр төрхөөр илрэхдээ тийм сайхан харагддаггүй. Бурхан багш бол хэмжээлшгүй их буяныг хураан мэндэлж, тэр нь бодит дүр төрхөд нь хүртэл илэрсэн байдаг учраас олон хүмүүс баярлан мөргөж, хүндлэн дээдэлж, чин сэтгэлээсээ тахин шүтдэг билээ. Яагаад гэвэл Бурхан багш хичнээн гэгээрсэн ч гэсэн ингээд болоо гэлгүй бурханы үйлийг хэрэгжүүлсээр байсан ба үүний үр дүнд ийм дүрслэхийн аргагүй үзэсгэлэнт дүр төрхийг олсон билээ. Бурхан нь үнэндээ дүр төрхгүй боловч ийнхүү бодит дүр төрхөөр хүн болж мэндэлсэн нь бидний хувьд туйлын их баярлаж талархмаар зүйл билээ.”

Дээрх үгэнд 2 чухал утга агуулагддаг. Нэгдүгээрт, хамаг амьтны дүр төрх ч гэсэн үндсэндээ Бурхан багштай адилхан боловч хийсэн буян нь хүрэхгүй, төөрөгдлөөр дүүрэн байдгийн улмаас бодит дүр төрх нь Бурхан багшийнхтай зүйрлүүлэхийн аргагүй, өрөвдмөөр сул дорой байдаг байна. Бурхан багштай адилхан юм чинь бодитоор илрэхдээ ч гэсэн Бурхан багштай адилхан байх боломжтой тул нэг талаар тийм болох юмсан гэсэн хүсэл эрмэлзэлтэй байж, нөгөөтэйгүүр буян хураасан эсэхээ дүгнэж цэгнэх хэрэгтэй.

Лянхуан Гурамсан судар нь бүхэлдээ дээрх үзэл санааг агуулсан байдаг. Тиймээс юуны түрүүнд энэ «үндсэн мөн чанар болох ижил

тэгш дүр төрх» ба «бодит ялгаатай дүр төрх»-ийн талаар сайтар ойлгож авах нь Лянхуан Гурамсан Сударыг унших чухал бэлтгэл болох юм.

Хоёрдугаарт, “Бурхан багш бодит дүр төрхөөр хүн болж мэндэлсэн нь бидний хувьд туйлын их баярлаж талархмаар зүйл” гэсэн хэсэг юм.

Шагжамүни будда энэ ертөнцөд мэндэлж, бурханы үйлийг сайтар хийсний үр дүнд төгс төгөлдөр чанарын эзэн болж, гэгээрлийн дээд түвшинд хүрсэн амьд жишээ юм. Тиймээс хүмүүс бид түүнийг нь дуурайгаад л байх хэрэгтэй ба Шагжамүни буддагийн маш хүнд бэрхшээлийг туулсан замаас хамаагүй амархан замаар бурханы түвшинд хүрэх боломжтой гэсэн үг юм. Шагжамүни будда энэ ертөнцөд мэндэлсэнд баярлах хэрэгтэй гэдэг нь ийм учиртай.

Бид сэтгэлдээ их баяр баяслыг тээж, Шагжамүни буддагийн дүрд мөргөж, сургаалыг нь өөрийн болгон хэрэгжүүлснээр Бурхан багшийн Номын дүртэй нэгэн бүхэл болж чадна. Ийнхүү Их Чимэглэлт бодисадвагийн үгэнд Гол шүтээний талаарх жинхэнэ утга агуулагдсан байна.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X10-16





Талархал ба эв найрамдал


7-р сар бол Урабон-э (амь насыг хайрласан өвөг дээдэстээ талархаж, буян хураадаг үе) сар бөгөөд өөрийн амь насны үнэ цэнэ, гайхамшигийг дахин тунгаан бодож, мэдрэх үе юм. Би ч гэсэн өвөг дээдсээс дамжиж ирсэн амь насандаа талархаж, тэдэндээ зориулж буян үйлдье гэж бодож байна.

Мөн өлсгөлөнгийн ертөнцөд зовж байгаа ээжийгээ авардаг Молом тойны домог ярианаас зөв үзэл, зөв бодол гэж юу болохыг суралцъя гэж бодож байна. Зовлонгийн шалтгаан нь хувиа хичээсэн үзэл, бодол юм. Тэндээс л уур хилэн болоод шунах сэтгэл төрж, улмаар хүмүүс хооронд зөрчилдөөн үүсгэдэг.

Ерөнхийлөгч энэ сарын сургаалдаа “зөв үг”-ний талаар заасан байна. Зөв үг гэдэг нь хүний үгийг анхааралтай сонсож, ойлгож, хувиа хичээсэн үзлээ дарж, бусадтай эв найрамдалтай амьдрахыг хэлнэ гэжээ.

Өвөг дээдэс, эцэг эхийнхээ хайранд талархаж, бусад хүмүүстэй эв найрамдалтай байхыг хичээн энэ сарыг өнгөрүүлье гэж бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Кооичи



We welcome comments on our e-newsletter Living the Lotus. Please send us your comments to the following e-mail address.
E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437
e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA
Tel: 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951
e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel : 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com
<http://home.earthlink.net/~rkchi/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi
110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai